



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1992 оны 02 сарын 13

№ 36.

Улаанбаатар
хот

УБХХЗ 93 4/35

Улаанбаатар хотын телевизийн
компани байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газрын 1992 оны 6 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. "Өлзий" пүүсийн материал техникийн баазыг үндэслэн одоогийн гүйцэтгэж байгаа ажил үүрэг дээр нэмж нийслэл хотын телевизийн нэвтрүүлэг бэлтгэн явуулах үүрэг бүхий Улаанбаатар хотын телевизийн "Өлзий" компанийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд 1992 оны 2 дугаар сарын 16-наас эхлэн байгуулж ажиллуулсугай.

2. Компаний дүрэм, байгууллагын шинэчилсэн зохион байгуулалт, цалингийн сан төсвийг боловсруулж батлуулахыг "Өлзий" компани /н.Сарантуяа/-д үүрэг болгосугай.

3. "Өлзий" компанийн телевизийн нэвтрүүлгийн болон редакцийн санхүүжилтэд зориулж эхний ээлжинд 5 сая төгрөг олгохыг хотын Санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРСГ/ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Signature]

Л.ЭНЭБИШ

[Signature]

Ц.БОЛДСАЙХАН